



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 1192

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2 дугаар бүлгийн 2.5.3 дахь заалт, 3 дугаар бүлгийн 3.2, 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 1-ийн хүрээнд шинээр бий болсон болон бий болох барилга, инженерийн шугам сүлжээ, авто замын байгууламж зэрэг эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтыг хариуцан ажиллах байгууллагуудыг тогтоох асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлыг хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болор-Эрдэнэ - Орлогч дарга

Гишүүд

С.Гантулга - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Б.Бүжинлхам - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

О.Батмөнх - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Г.Жанлавцогзол - Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгжийн Ерөнхий инженер

М.Энхболд - Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

11505800008

Н.Одхүү 2	-Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Инженерийн бодлогын хэлтсийн дарга
Ж.Пүрэвжамц	-Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын Инженерийн бодлого, хяналтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	
Д.Итгэл	-Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

2. Ажлын явцыг тухай бүр тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА